



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХАН ХЭНТИЙН УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: АХГ-2022/141/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитор: С.Алтанхуяг
Утас: 262618 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Нью Эстимэйтор Аудит ХХК
Захирал: Т.Бүжидмаа
Утас: 95157097, 98000688 Цахим хаяг: jukhertar@yahoo.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖС	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайд
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХГХЗ	Улсын Тусгай Хамгаалалттай Газрын Хамгаалалтын Захиргаа



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХАН ХЭНТИЙН УЛСЫН ТУСГАЙ
ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Б.ХАШМАРГАД ТАНАА

2022.02.25 № 07/371
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хан Хэнтий улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хан Хэнтий улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	135,807,743.26	175,835,207.96
33	АВЛАГА	2,861,820.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,861,820.00	00.00
34	УРЬДЧИЛГАА	00.00	60,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	60,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	132,945,923.26	115,835,207.96
354	Хангамжийн материал	132,945,923.26	115,835,207.96
35410	Бичиг хэргийн материал	4,633,970.00	00.00
35420	Аж ахуйн материал	52,974,977.00	63,240,243.70
35430	Сэлбэг хэрэгсэл	15,360,100.00	12,000,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,751,050.00	3,602,820.00
35450	Барилгын засварын материал	14,432,182.00	150,000.00
35470	Бусад хангамжийн материал	42,793,644.26	36,842,144.26
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,020,916,139.66	1,374,511,032.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,020,916,139.66	1,374,511,032.35
392	Биет хөрөнгө	1,008,244,806.46	1,362,259,699.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	464,346,498.13	463,923,028.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(55,062,335.96)	(76,598,323.80)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	540,428,368.25	814,680,640.97
39204	Хуримтлагдсан элэгдэл	(188,750,011.66)	(263,216,113.69)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	190,199,957.04	195,318,827.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	(96,246,093.35)	(123,569,001.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	216,261,113.99	212,813,325.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(86,807,395.05)	(111,203,780.66)
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,884,705.00	105,401,965.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,009,999.93)	(12,063,008.02)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	00.00	156,772,140.00
393	Биет бус хөрөнгө	12,671,333.20	12,251,333.20
39301	Програм хангамж	3,900,000.00	3,900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,366,666.80)	(1,786,666.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,138,000.00	10,138,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,156,723,882.92	1,550,346,240.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,007,750.20	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,007,750.20	00.00
413	Өглөг	3,007,750.20	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,853,000.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	154,750.20	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,153,716,132.72	1,550,346,240.31
51	Засгийн газрын хувь оролцоо	1,153,716,132.72	1,550,346,240.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	277,853,666.84	277,853,666.84
51101	Өмч: - төрийн	277,853,666.84	277,853,666.84
512	Хуримтлагдсан үр дүн	840,285,933.04	1,236,916,040.63
51210	Өмнөх үеийн үр дүн	840,285,933.04	840,709,403.04
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	396,630,107.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	35,576,532.84	35,576,532.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,156,723,882.92	1,550,346,240.31

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,432,605,650.45	1,664,999,593.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	286,780,167.45	243,141,333.90
120	Нийтлэг татварын бус орлого	286,780,167.45	243,141,333.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	286,780,167.45	243,141,333.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,020,500.00	37,974,017.48
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	252,759,667.45	205,167,316.42
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,145,825,483.00	1,421,858,260.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	847,748,100.00	898,276,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	847,748,100.00	826,276,000.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00	72,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	298,077,383.00	523,582,260.00
131101	төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	85,738,960.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,231,483.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	209,845,900.00	437,843,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,286,889,103.91	1,268,369,486.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,286,889,103.91	1,268,369,486.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,120,820,060.45	1,140,885,562.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	571,529,705.00	601,101,400.00
210101	Үндсэн цалин	353,405,896.92	388,205,700.00
210102	Нэмэгдэл	134,631,201.02	169,095,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,101,562.25	43,800,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	58,391,044.81	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,796,470.68	81,148,509.04
210201	Тэтгэврийн даатгал	47,954,882.68	57,104,509.04
210202	Тэтгэмжийн даатгал	4,933,271.00	6,011,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,136,108.00	4,808,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,070,201.00	1,202,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,702,008.00	12,022,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,126,642.00	17,421,627.29
210301	Гэрэл, цахилгаан	414,242.00	540,401.29
210302	Түлш, халаалт	5,258,400.00	3,249,226.00
210303	Цэвэр, бохир ус	4,000.00	00.00
210304	Байрны түрээс	17,450,000.00	13,632,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	80,266,979.15	64,307,890.37
210401	Бичиг хэрэг	4,120,933.00	19,341,486.00

210402	Тээвэр, шатахуун	38,522,950.00	36,975,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,782,199.81	7,051,294.37
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,869,391.34	940,000.00
210408	Бараа материал акталсны зардал	18,971,505.00	00.00
2105	Нормативд зардал	50,723,802.16	18,959,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	50,723,802.16	18,959,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,956,780.00	76,757,409.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,000.00	6,977,177.00
210604	Урсгал засвар	11,929,780.00	69,780,232.00
2107	Томилолт, зочны зардал	4,093,000.00	10,253,560.00
210702	Дотоод албан томилолт	4,093,000.00	10,253,560.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,886,307.25	102,506,186.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,651,295.25	97,175,010.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	3,300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	812,000.00	802,440.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	975,112.00	968,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	270,400.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	177,500.00	185,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	240,440,374.21	168,429,280.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,803,870.00	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	950,000.00	33,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	153,686,504.21	167,395,580.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	166,069,043.46	127,483,924.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,064,300.00	96,600,506.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,220,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	95,380,506.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	67,064,300.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	99,004,743.46	30,883,418.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,004,743.46	30,883,418.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	145,716,546.54	396,630,107.59
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	145,716,546.54	396,630,107.59

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	277,853,666.84	35,576,532.84	567,996,312.56	881,426,512.24
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	277,853,666.84	35,576,532.84	567,996,312.56	881,426,512.24
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	132,626,412.38	132,626,412.38
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,853,666.84	35,576,532.84	840,285,933.04	1,153,716,132.72
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	277,853,666.84	35,576,532.84	840,285,933.04	1,153,716,132.72
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00		00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	277,853,666.84	35,576,532.84	840,285,933.04	1,153,716,132.72
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	396,630,107.59	396,630,107.59
2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,853,666.84	35,153,062.84	1,236,916,040.63	1,550,346,240.31

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,180,095,983.00	1,391,144,097.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,270,500.00	38,424,017.48
120	Нийтлэг татварын бус орлого	34,270,500.00	38,424,017.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,270,500.00	38,424,017.48
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,270,500.00	38,424,017.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,145,825,483.00	1,352,720,080.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	847,748,100.00	826,276,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	847,748,100.00	826,276,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	298,077,383.00	526,444,080.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	85,738,960.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,231,483.00	2,861,820.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	209,845,900.00	437,843,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,180,095,983.00	1,391,144,097.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,180,095,983.00	1,391,144,097.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,011,165,119.54	1,263,404,373.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	549,586,018.38	601,101,400.00
210101	Үндсэн цалин	335,462,210.30	388,205,700.00
210102	Нэмэгдэл	130,631,201.02	169,095,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,101,562.25	43,800,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	58,391,044.81	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,796,470.68	81,148,600.00
210201	Тэтгэврийн даатгал	47,954,882.68	57,104,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,933,271.00	6,011,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,136,108.00	4,808,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,070,201.00	1,202,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,702,008.00	12,022,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,628,642.00	18,109,627.29
210301	Гэрэл, цахилгаан	774,242.00	540,401.29
210302	Түлш, халаалт	4,385,700.00	3,937,226.00
210303	Цэвэр, бохир ус	18,700.00	00.00
210304	Байрны түрээс	17,450,000.00	13,632,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,791,599.81	42,114,951.37
210401	Бичиг хэрэг	1,316,100.00	1,021,857.00
210402	Тээвэр, шатахуун	39,171,000.00	33,301,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,782,199.81	7,051,294.37
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,522,300.00	740,100.00
2105	Нормативд зардал	8,976,600.00	336,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,976,600.00	336,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	120,574,020.00	158,546,195.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	92,683,420.00	47,546,200.00
210604	Урсгал засвар	27,890,600.00	110,999,995.00
2107	Томилолт, зочны зардал	4,093,000.00	10,253,560.00
210702	Дотоод албан томилолт	4,093,000.00	10,253,560.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	126,436,098.67	340,596,013.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	124,128,586.67	335,108,137.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	3,300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	812,000.00	802,440.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	975,112.00	968,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	270,400.00	167,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,282,670.00	11,197,426.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,953,770.00	10,167,676.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,328,900.00	1,029,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	168,930,863.46	127,739,724.12
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	101,866,563.46	30,883,418.12
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	101,866,563.46	30,883,418.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,064,300.00	96,856,306.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,475,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		95,380,506.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	67,064,300.00	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	834,276,000.00	833,816,604.70	459,395.30	99.9
УРСГАЛ ЗАРДАЛ	834,276,000.00	833,816,604.70	459,395.30	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	832,776,000.00	832,340,804.66	435,195.34	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	601,101,400.00	601,101,400.00	0.00	100.0
Үндсэн цалин	388,205,700.00	388,205,700.00	0.00	100.0
Нэмэгдэл	169,095,700.00	169,095,700.00	0.00	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	43,800,000.00	43,800,000.00	0.00	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,148,600.00	81,148,600.00	0.00	100.0
Тэтгэврийн даатгал	57,104,600.00	57,104,600.00	0.00	100.0
Тэтгэмжийн даатгал	6,011,000.00	6,011,000.00	0.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	4,808,800.00	4,808,800.00	0.00	100.0
Ажилгүйдлийн даатгал	1,202,200.00	1,202,200.00	0.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	12,022,000.00	12,022,000.00	0.00	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,760,900.00	14,407,427.29	353,472.71	97.6
Гэрэл, цахилгаан	866,600.00	540,401.29	326,198.71	62.4
Түлш, халаалт	3,947,100.00	3,937,226.00	9,874.00	99.7
Цэвэр, бохир ус	17,400.00	00.00	17,400.00	
Байрны түрээс	9,929,800.00	9,929,800.00	0.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	32,444,400.00	32,414,951.37	29,448.63	99.9
Бичиг хэрэг	1,033,800.00	1,021,857.00	11,943.00	98.8
Тээвэр, шатахуун	28,301,400.00	28,301,700.00	-300.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,368,800.00	2,351,294.37	17,505.63	99.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	740,400.00	740,100.00	300.00	100.0
Нормативт зардал	336,600.00	336,600.00	0.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	336,600.00	336,600.00	0.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	296,200.00	296,200.00	0.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	296,200.00	296,200.00	0.00	100.0
Томилолт, зочны зардал	3,534,400.00	3,534,300.00	100.00	100.0
Дотоод албан томилолт	3,534,400.00	3,534,300.00	100.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,090,400.00	98,071,576.00	18,824.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	92,583,700.00	92,583,700.00	0.00	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,300,000.00	3,300,000.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	812,000.00	802,440.00	9,560.00	98.8
Тээврийн хэрэгслийн татвар	977,700.00	968,436.00	9,264.00	99.1
Тээврийн хэрэгслийн оношлогоо	167,000.00	167,000.00	0.00	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00	0.00	100.0

Бараа үйлчилгээний бусад зардал	1063100.00	1029750.00	33,350.00	96.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,063,100.00	1,029,750.00	33,350.00	96.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,475,800.00	24,200.00	
Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,475,800.00	24,200.00	98.4
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	1,475,800.00	24,200.00	98.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	834,276,000.00	833,816,604.70	459,395.30	99.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	826,276,000.00	826,276,000.00	0.00	100.0
Улсын төсвөөс санхүүжих	826,276,000.00	826,276,000.00	0.00	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,000,000.00	38,424,017.48	(30,424,017.48)	480.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	38,424,017.48	(30,424,017.48)	480.3
АЖИЛЛАГСАДЫН ТОО	56	56	0.00	100.0
Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	38	38	0.00	100.0
Үйлчлэх ажилтан	9	9	0.00	100.0
Гэрээт ажилтан	8	8	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	526,444,080.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	526,444,080.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	431,063,568.70
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	3,702,200.00
Байрны түрээс	-	3,702,200.00
Хангамж, бараа материалын зардал	-	9,700,000.00
Тээвэр, шатахуун	-	5,000,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	4,700,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	158,249,995.00
Багаж, техник, хэрэгсэл	-	47,250,000.00
Урсгал засвар	-	110,999,995.00
Томилолт, зочны зардал	-	6,719,260.00
Дотоод албан томилолт	-	6,719,260.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	242,524,437.70
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	242,524,437.70
Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,167,676.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,167,676.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	95,380,511.30
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	05.30
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	05.30
Бусад урсгал шилжүүлэг	-	95,380,506.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	95,380,506.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	526,444,080.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	526,444,080.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	85,738,960.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,861,820.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	437,843,300.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-аас 2022 оны 2 дугаар сарын 23-ны хооронд Нью Эстимэйтор Аудит ХХК-ийн ахлах аудитор Ж.Үхэртар, аудитор Б.Алтанцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг захирал Т.Бүжидмаа хэрэгжүүлсэн.

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь Хан Хэнтий дархан цаазат газар, Өндөрхаан уулын байгалийн цогцолборт газар, Хангал нуурын байгалийн дурсгалт газар, Бэндэръяа уулын байгалийн дурсгалт газрын хилийн зааг дотор багтаж буй газар нутгийн биологийн төрөл, зүйл томоохон гол мөрөн, байгаль түүх, соёлын дурсгалын байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, шинжлэн судалж зүй зохистой ашиглах үйл ажиллагааг зохицуулах үндсэн чиг үүрэгтэй байгууллага юм.

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх бодлогын хэрэгжилтийг хангуулах
- Хамгаалалтын менежментийг хэрэгжүүлж, судалгаа, шинжилгээний ажил хийх
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялалын дэд бүтцийг бий болгох, хамтын ажиллагааг сайжруулах
- Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, тусгай хамгаалалттай газрын хамгааллын менежментэд олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/700 дугаар тушаалаар шинээр хамгаалалтын захиргаа байгуулагдах хүртэл хугацаанд Ноён уулын дархан цаазат газрыг хариуцан ажиллах болсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгаль орчин, аялал, жуулчлалын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудиторын тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар аудит хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтийг нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн нийт зардлаар 1,286,889.1 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 25,737.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 20,590.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 425,791.6 мянган төгрөгөөр буюу 36.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2,861.8	0.00	(2,861.8)
Урьдчилж гарсан тооцоо	0	60,000.0	60,000.0
Бараа материал	132,945.9	115,835.2	(17,110.7)
Үндсэн хөрөнгө	1,020,916.1	1,374,511.0	353,594.9
Нийт хөрөнгө	1,156,723.8	1,550,346.2	393,622.3
Өр төлбөр	3,007.7	0	(3,007.7)

Засгийн газрын хувь оролцоо	1,153,716.1	1,550,346.2	396,630.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,156,723.8	1,550,346.2	393,622.3

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага данс үлдэгдэлгүй болж 2,861.8 мянган төгрөгөөр буурсан нь Байгаль хамгаалах уур амьсгалын сангаас авлага авсан;
- Урьдчилж гарсан зардал 60,000.0 мянган төгрөг болсон нь Тусгай хамгаалалттай газар нутгийг сурталчлах хамгаалалтыг сайжруулах зорилгоор контент нэвтрүүлэг хийх, сургалт сурталчилгааны материал хэвлүүлэх гэрээ байгуулсан боловч бараа, үйлчилгээг тайлант оноос өмнө хүлээн авч чадаагүй байна;
- Бараа материалын дансны үлдэгдэл 115,835.2 мянган төгрөг болж 17,110.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд барилгын материал дансанд бүртгэлтэй байсан засварын материалыг гал хамгаалах байр засварлахад ашигласан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,406,680.2 мянган төгрөг болж 385,764.1 мянган төгрөгөөр өссөн нь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн хөрөнгө оруулалтаар 85,464.9 мянган төгрөг, “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” төслөөс 202,252.3 мянган төгрөг, Монгол улсын засгийн газрын 28-р тогтоолоор 72,000.0 мянган төгрөг, үйл ажиллагааны давсан орлогоос 118,825.7 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 589 дүгээр тогтоолоор 16,201.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан;
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,582,515.4 мянган төгрөг болж 428,799.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 232,393.9 мянган төгрөгөөр буюу 16.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэмэлт санхүүжилтийн орлого байна. Энэ нь тайлант хугацааны үйл ажиллагааны хүрээнд бий болсон самрын хураамжийн давсан орлогоос нэмэлтээр санхүүжүүлэх эрх авсантай холбоотой орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 50,688.7 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан эд хогшил урсгал засвар, болон төрөөс иргэдэд олгосон тэтгэмж, урамшуулал зардлууд байна. Эд хогшил урсгал засварын зардал өссөн нь байгаль хамгаалагчийн пос, мэдээллийн төв, захиргааны байранд урсгал засвар хийсэн. Төрөөс иргэдэд олгосон тэтгэмж, урамшуулал зардал гарсан нь давсан орлогоос ажилчдын нийгмийн асуудал шийдвэрлэхэд олгосон тэтгэмж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,158,708.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,158,708.7 төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 310,461.2 мянган төгрөгөөр бууруулж 848,247.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 848,247.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 840,247.5 мянган төгрөгийг улсын төсвөөс 8,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Баталсан төсвөөс Засгийн газрын 43-р тогтоолын хүрээнд 13,971.3 мянган төгрөгөөр бууруулж санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 826,276.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 38,424.0 мянган төгрөг, нийт 864,700.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 833,816.6 мянган төгрөгийг зарцуулж 30,883.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 833,816.6 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	741,692.3	741,232.9	(459.40)	99.9
1.2	80221	Гэрээгээр ажиллагсдын зардал	59,714.4	59,714.4	0.00	100
1.3	81703	Ургамал хамгааллын зардал	18,679.2	18,679.2	0.00	100
1.4	80101	Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардал	14,190.1	14,190.1	0.00	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн /GIZ/ төслөөс 85,738.9 мянган төгрөг, Байгаль орчин, уур хамгаалах сангаас 2,861.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 437,843.3 мянган төгрөг, нийт 526,444.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Түнхэл тосгоны мэдээллийн төвийн их засварт 69,726.2 мянган төгрөг, эко 00 бариулахад 15,738.7 мянган төгрөг, галын байр барихад 38,298.3 мянган төгрөг, хашаа, зөгийн зоорь болон автомашины граш бариулахад 111,771.6 мянган төгрөг, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг сурталчлах таниулахад 65,593.7 мянган төгрөг, түймэр гарсан үед богино хугацаанд унтраах байнгын бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд 77,940.1 мянган төгрөг, ажилчдын нийгмийн асуудал шийдвэрлэхэд 95,380.5 мянган төгрөг тус тус зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны эрхэм зорилгын хүрээнд тайлант онд БОАЖС-н 2020 оны А/599 тушаалын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд, нийт 18 га талбайд 37.0 мянган шинэсний тарьц суулгасан. Дархан газрын хамгаалалтын бүс болох Минж гол, Жаргалантын рашаан орчимд Шинжлэх

ухааны хүрээлэн, Байгалийн түүхийн музей, Төв Азийн хөрс судлалын холбоо болон их дээд сургуулиудын нийт 18 судлаачдын баг биологийн олон янз байдлын судалгааг хийж гүйцэтгэсэн байна. Хамгаалалтын захиргаа ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ургамал судлаачтай хамтран байгальд ховордож байгаа эмийн ургамлыг тарималжуулах төсөл боловсруулан, санхүүжилтийг шийдвэрлэн ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Хан Хэнтийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 123 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын гэрээ, гэрээ дүгнэсэн актыг байршуулаагүй, хугацаа хоцроосон 25 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчил давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайлант онд хийгдсэн худалдан авалтаас гэрээнд заасан хугацаанд бараа үйлчилгээг хүлээн аваагүй нийт 60,000.0 мянган төгрөг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8 “төсвийг зохистой удирдаж өр, авлага үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлтгэн нийлүүлэгч гэрээний хугацааг хэрэгжүүлж ажиллахад хяналт тавих, гэрээтэй холбоотой журмын заалтуудыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмж өгөх

2. Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны тайлант онд батлагдсан төсөв нь 848,247.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 833,816.6 мянган төгрөг байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43-р тогтоолын 1.1 “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт

гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д үндэслэн шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, албан шаардлага өгөх

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар илэрсэн 15,738.6 мянган төгрөгийн алдааг залруулж, өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад хэрэгжсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 23 мэдээг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээтэй холбоотой гэрээ, гэрээ дүгнэсэн актыг байршуулаагүй, орлогын 5,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ орхигдуулсан, мөнгөн хөрөнгө зарцуулахтай холбоотой 12 мэдээний шийдвэрийн хуулбарыг байршуулаагүй 1 албан шаардлагын биелэлт 60.3 хувь, 2,477.2 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	5,000.0	0	5,000.0	-	-	60.3
Зөвлөмж	1	2,477.2	1	2,477.2	-	-	100.0
Нийт дүн	3	7,477.0	2	7,477.2			-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын санхүүгийн тайланд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 157,110.9 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 149,965.6 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 7,145.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 2 алдаа, зөрчлийн дүн 7,145.5 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 25,737.7 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалын өртөгт хамаарах 683.7 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд зардлаар илэрхийлсэн;
- Мэдээлэл сургалт сурталчилгааны төвийн байрыг засварлах их засварын 66,915.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийг үр дүнгийн тайланд зардлаар тайлагнасан;
- Үндсэн хөрөнгө болох автомашины граш бариулсан 82,366.9 мянган төгрөгийн гүйцэтгэлийн ажлыг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 12 ААН-ээс 6,474.2 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцээгүй тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авсан бараа, үйлчилгээг НӨАТ-ын төлбөрийн цахим баримтаар баталгаажуулах, и баримтын цахим системд хяналт тавин ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Цалин хөлсний тооцоололтой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 4 удаагийн 671,1 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл цалин олгох анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно” гэсэн заалттай нийцээгүй тохиолдсон байх ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цалингийн нэмэгдэл олгохдоо анхан шатны баримтад үндэслэх, баримтын бүрдэлд хяналт тавьж, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	ХХУТХГХЗ	АХГ-2022/141 /НА-СТА-ТХН	Бараа материал худалдан авахдаа НӨАТ-н дүнг салган зардалд дансанд бүртгэсэн, дансны харьцаа буруу хийсэн	СҮДТ-ийн тайланд залруулга хийсэн	1	683.7	1	683.7								
2	ХХУТХГХЗ	АХГ-2022/141 /НА-СТА-ТХН	Их засварын зардлыг урсгал засвараар тайлагнасан	СҮДТ-ийн тайлан болон СБТ-нд үлдэгдлийг залруулсан	1	82,366.9	1	82,366.9								
3	ХХУТХГХЗ	АХГ-2022/141 /НА-СТА-ТХН	Ажил гүйлгээг буруу ангилж бүртгэсэн. Дуусаагүй барилга-г урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэсэн	СБТ-д анги залруулсан залруулсан	1	66,915.0	1	66,915.0								
4	ХХУТХГХЗ	АХГ-2022/141 /НА-СТА-ТХН	Тайлант онд 4 удаагийн 671,1 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгох анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу байна.	НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэснийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	671.1								1	671.1	
5	ХХУТХГХЗ	АХГ-2022/141 /НА-СТА-ТХН	Тайлант онд 12ААН-ээс 6,474.2 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.	Төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах	1	6,474.2								1	6,474.2	
Дүн					5	157,110.9	3	149,965.6						2	7,145.3	

Хан Хэнтийн УТХГ-ын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал														
6	ХХУТХГХЗ	АХГ-2022/141 /НА-СТА-ТХН	Засгийн газрын 43-р тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй	Төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төрөөс гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах	1						1	-		
7	ХХУТХГХЗ	АХГ-2022/141 /НА-СТА-ТХН	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 123 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын гэрээ, гэрээ дүгнэсэн акт байршуулаагүй, хугацаа хоцроосон 25 мэдээлэл	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд албан шаардлага өгөх.	1	-					1	-		
8	ХХУТХГХЗ	АХГ-2022/141 /НА-СТА-ТХН	Тайлант онд хийгдсэн худалдан авалтаас гэрээнд заасан хугацаанд бараа үйлчилгээг хүлээн аваагүй нийт 60,000.0 мянган төгрөг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн байна.	Бэлтгэн нийлүүлэгч гэрээний хугацааг хэрэгжүүлж ажиллахад хяналт тавих, гэрээтэй холбоотой журмын заалтуудыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмж өгөх	1	60,000.0								1 60,000.0
Дүн					3	60,000.0								1 60,000.00
Нийт дүн					8	217,110.9	3	149,965.6			2	-		3 67,145.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 193/АО150054

Улаанбаатар хот

АХГ-2022/141/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд баталсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарган ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулах, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, үргүй зардал гаргахгүй байхад анхаарч, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга Б.Хашмаргад, нягтлан бодогч П.Оюунтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
НЬЮ ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Ж.ҮХЭРТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109 9019120000 10.10.10.20\Bichig_Kherek\Alban-Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-202.Docx

0010800050



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 192/АУ/50054
АХБ-2022/41/НА-СТА-043

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 25 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын гэрээ, гэрээ дүгнэсэн актыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулах зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, үргүй зардал гаргахгүй байхад анхаарч, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга Б.Хашмаргад, нягтлан бодогч П.Оюунтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
НЬЮ ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Ж.ҮХЭРТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-203.Docx

0010300653

